



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1997 оны 02 дугаар
сарын 15 өдөр

Дугаар 6-35

Улаанбаатар
хот

Тушаал, захирамж хэрэгжүүлэх тухай

1. Монгол улсын Засгийн газрын 1995 оны 192 дугаар тогтоол, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 1997 оны А/08, А/6 тоот тушаал, захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор нийслэлийн Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын албаны дүрмийг нэг, тус албаны орон тоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт орсонтой холбогдуулан Ч.Үржээг үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

3. Нийслэлийн Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын албаны даргаар Энэбиш овогтой Сэрждадамг 1997 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс томилж, түүний албан тушаалын цалинг ТҮ-11-30900 төгрөгөөр тогтоосугай.

4. Санхүүгийн баримтын шалгалтыг энэ оны 02 дугаар сард багтаан хийж танилцуулахыг санхүүгийн хяналт шалгалтын алба (н.Ургамал)-нд даалгасугай

5. Нийслэлийн эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын албаны даргын ажил хүлээлцүүлэх комиссыг томилж ажиллуулахыг Эрүүл мэндийн газар (Г.Буян-Өлзий)-т даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.НАРАНЦАЦРАЛТ



**НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ АХУЙ ХАЛДВАР
СУДЛАЛЫН ХЯНАЛТЫН АЛБАНЫ
ДҮРЭМ**

УХБ:11

НЭГ. Нийтлэг үндэслэл.

1. Нийслэлийн эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын алба /цаашид энэ дүрэмд алба гэнэ/ нь эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтыг Нийслэлийн хэмжээнд удирдаж зохион байгуулж, эрүүл ахуй, халдвар судлалын хууль тогтоомж, норм, хэм хэмжээг албадан сахиулах захиргааны хяналтын мэргэжлийн байгууллага мөн.
2. Алба нь Монгол улсын хууль тогтоомж, эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтын дүрэм, эрүүл мэндийн сайдын тушаал, Нийслэлийн Засаг даргын захирамж, эрүүл ахуй халдвар судлалын улсын ерөнхий байцаагч, эрүүл мэндийн газрын даргын тушаалыг үйл ажиллагаандаа удирдлага болгоно.
3. Албыг Нийслэлийн Засаг даргын захирамжаар томилогдсон дарга удирдана. Албаны дарга нь мэргэссэн байх бөгөөд эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын Нийслэлийн улсын ахлах байцаагч байна.
4. Албыг мэргэжил, арга зүйн удирдлагаар эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтын алба хамгах бөгөөд Нийслэлийн алба ахлаа Нийслэлийн Засаг дарга түүний Тамгын газар, эрүүл ахуй халдвар судлалын улсын хяналтын албанд тус тус тайлагнана.
5. Албаны дарга нь Монгол улсын хууль тогтоомж, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, эрүүл ахуй, халдвар судлалын улсын ерөнхий байцаагчийн шийдвэрт нийцүүлэн Нийслэл, дүүргийн албаны үйл ажиллагаанд дараж мөрдөх шийдвэр гаргаж хэрэгжүүлнэ.
6. Алба нь Нийслэлийн төсвөөс санхүүжинэ албан хэргийн хуудас, тэмдэг, харилцах дэнстэй хуудгийн этгээд байна.

ХОЁР. Албаны үүрэг.

1. Нийслэлийн хэмжээнд хот суурин, бэрилга байгууламжийн газар олголт, зураг төсөл, явцыг хинэх ажиллалтад хүлээн авах зэргээр бэрилга төлөвлөлтийн эрүүл ахуйн норм, норматив хангаж буй эсэхэд урьдчилсан хяналт хийж дүгнэлт гаргана.
2. Шинэ бүтээгдэхүүн, зор, технолог, техникийн нөхцөл нь хүний эрүүл мэндэд тохивох эсэх талаар хяналт тавьж дүгнэлт гаргана.
3. Дүүргүүдийн эрүүл ахуй халдвар судлалын хяналтын албаны байнгын хяналтын объектод тавьж буй хяналт шалгалтын ажлын

чанар, үр дүнг шалгаж үнэлэлт дүгнэлт өгнө.

4. Хүрээлэн буй орчны бохирдолт, ус хангамжийн төвлөрсөн эх булгийн эрүүл ахуйн норм дүрмийн биелэлтэд хяналт тавьж хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж буй байдалд дүн шинжилгээ хийнэ.

5. Нийслэлийн мэргэжлийн хяналтын бусад холбогдох байгууллагуудтай хамтарч нэгдсэн график, удирдамжтай хяналт шалгалт, операциудыг зохион байгуулж дүгнэнэ.

6. Эрүүл ахуй, халдвар судлалын хяналт шалгалтын сүүлийн үеийн шинэ мэдээ, мэдээллээр төр захиргаа, салбар нэгж байгууллага, иргэдийг хангаж, хүн амын дунд эрүүл мэндийн мэдлэг, боловсрол олгох сургалт, сурталчилгаа явуулж, мэргэжлийн сонин, сэтгүүлтэй байна.

7. Дүүргийн эрүүл ахуй халдвар судлалын хяналтын албаны эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтын байцаагчид, мэргэжилтэнүүдийг мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангаж, мэдлэг боловсрол чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авна.

8. Эрүүл ахуй, халдвар судлалын хяналт, нэгдсэн лабораторийн шинжилгээг дүүргийн хяналтын албандынхтай зэрэгцэж давхцалгүй зохион байгуулаж, лабораторийн өндөр мэдлэг, сүүлийн үеийн багаж, тоног төхөөрөмж, урсгалгаар хангах, шинжилгээний шинэ арга, стандарт нэвтрүүлэх замаар улсын хяналтын шинжлэх ухааны үндэслэлийг дээшлүүлнэ.

9. Эрүүл ахуй халдвар судлалын хяналтын байцаагчдын мэдлэг боловсрол үр чадварыг дээшлүүлэх, эдийн засгийн хөгжилтэй орнуудад туршлага судлах, дадлагажуулах арга хэмжээ авна.

10. Эрүүл ахуй халдвар судлалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон байгууллага, иргэдийн болон улсын байцаагчдын үйл ажиллагаатай холбогдсон санал, гомдол, өргөдөл, хүсэлтийг хүлээн авч барагдуулна.

11. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн холбогдолтой хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдож гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх.

12. Хөдөлмөрийн стандартын хэрэгжилт хөдөлмөрийн нөхцөл, техникийн аюулгүй ажиллагаа нь улсын стандарт шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих.

ГУРАВ. Албаны эрх.

1. Алба нь эрүүл ахуй халдвар судлалын асуудлаар өөрийн орны ба гадаадын мэргэжлийн байгууллагатай шууд харилцаа тогтоож гэрээ хэлцэл байгуулж ажиллана.

2. Алба нь байгууллага, аж ахуйн нэгжүүдийн удирдагчид шийдвэр, түүний хэрэгжилт, үйл ажиллагаа нь эрүүл ахуй халдвар

судлалын дүрэм, журам, норм хэмжээнд харшилж, хүний эрүүд мөндөд хохирол учруулах үндэстэй байвал уг шийдвэрийн дагуу явагдаж буй үйл ажиллагааг зөрчил авилгах хүртэл зогсооно.

3. Эрүүл ахуй халдвар судлалын холбогдолтой зөрчил, халдвар хордлогоос сэргийлэх асуудлаар зарлал, мэдээлэл явуулна.

4. Албаны зохион байгуулалтын бүтэц, орон тоог баталж, улсын байцаагч мэргэжилтэн, ажилчдыг ажилд томилох, чөлөөлөх, цалинг нь тогтоох, хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажил үүргийн хуваарийг батлах, хууль тогтоомжид заасан нэмэгдэл, нэтгэмж тусламж үзүүлэх, шагнал урамшил олгох, сахилгын арга хэмжээ авах эрх эдлэнэ.

5. Хүний эрүүд мөндөд сөрөг нөлөөлөх хүчин зүйлийг арилгуулахад төв захиргааны нэгж байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг татан оролцуулах.

6. Баталсан төсөв, зардлыг төсвийн хуулийн хүрээнд захиран зарцуулах.

7. Эрүүл ахуй халдвар судлалын хяналтын дүрэмд заагдсан бусад эрхийг эдлэнэ.



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ АХУЙ ХАЛДВАР
СУДЛАЛЫН ХЯНАЛТЫН АЛБАНЫ ОРОН
Т О О.

УХВНН

Ажил мэргэжил.

Нийслэлийн ЭАХС-ын
албаны ажиллах орон
тоо.

1. Дарга	I
2. Эрүүл ахуйн халдвар судлалын боловсрол сургалт сурталчилгаа хариуцсан менежер	I
3. Хүнсний технологич, эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч, их эмч	I
"Хотжилт-эрүүл мэнд" хөтөлбөрийн зохицуулагч бөгөөд орчны эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч их эмч	I
5. Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч	I
6. Хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч	I
7. Гэдэс, амьсгалын зам болон доторд халдвар, вакцин хариуцсан хяналтын улсын байцаагч	2
8. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч	I
9. Паразитологч - биологич	I
10. Химич, хор судлагч	I
11. хими, нян судлалын лаборант	4
12. операторчин	I
13. нядав	I
14. ня-бо	I
15. эрүүл ахуй халдвар судлалын бага эмч	I
16. манаач-словарь-цахилгаанчин	5
17. үйлчлэгч	2
18. шил угаагч	2
19. цагаан хэрэглэл угаагч	I
20. автоклавчин	I
21. зоолооч	I
22. сүүн хүч, архив, дотоод ажил хариуцсан ажилтан	I
23. эрүүл зүйн нян судлагч их эмч	2

БҮГД:

34